



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ

АСУУЛТ

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.09.15 № 59

**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл
ахуйн талаар**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар дараах асуултыг тавьж байна.

1.2027 оны төсвийн төсөлд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас аймаг, дүүрэгт хуваарилсан санхүүжилтийг хассан шалтгаан, мөн 2025-2026 онд тус сангийн хөрөнгөөр бий болгосон ажлын байрны тоон мэдээллийг аймаг, дүүргээр;

2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сангийн 2026 оны төсөв, зарцуулалт, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, осол аваарын тоо, төсөвт тавигдсан зардлын гүйцэтгэлийн нарийвчилсан задаргаа;

3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдэд үзүүлсэн дэмжлэг, нөхөн сэргээх тусламж үйлчилгээ, хамрагдсан иргэдийн тоо, зарцуулсан төсөв болон үр дүнгийн талаарх мэдээлэл;

4.Ажилгүйдлийн даатгалын сангийн 2026 оны төсөв, гүйцэтгэл, ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэдийн тоо, олгосон тэтгэмжийн нийт хэмжээ болон зарцуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

С.ЭРДЭНЭБАТ

2026000173